

ХАЛДВАРТ БУС ӨВЧИН (ХБӨ) - НИЙ ТАЛААРХ ХҮН АМЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ- 2013

ТОВЧ ХУРААНГУЙ

Уг судалгааг Монголын Мянганы Сорилын Сангийн Эрүүл Мэнд төслийн хүрээнд гүйцэтгэлээ.

Үндэсний түвшинд давтан явуулсан энэхүү судалгааны зорилго нь халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг хандлагыг үнэлэх, хүн амын дундах мэдлэг, дадал, хандлагын одоогийн байдлыг дүгнэх, ММСС-ийн Эрүүл Мэнд төслөөс хүн амын дунд эрүүл мэндийн эерэг зан үйлийг төлөвшүүлэх, өвчлөх эрсдэлийг бууруулах, өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр өргөн хүрээнд явуулж буй эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлоход оршино.

Судалгаагаар дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

1. ХБӨ, тэдгээрийн зан үйлийн анхдагч болон хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн талаарх хүн амын мэдлэг, хандлагын одоогийн байдлыг судлан тогтоох,
2. Зүрх судасны өвчин, чихрийн шижин, тэдгээрээс сэргийлэх, хянах аргуудын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг судлах,
3. Хөх, умайн хүзүүний өмөн, тэдгээрээс сэргийлэх, эрт илрүүлэх аргуудын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадлыг судлах,
4. Урьдчилан тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх, тэдгээрийг суурь судалгааны дүнтэй харьцуулан судалж дүгнэх

Судалгаанд Монгол улсын 21 аймгийн 24 сум, Улаанбаатар хотын 7 дүүргийн 19 хорооны нийт 3396 хүн хамрагдлаа. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2012 оны 12-р сарын 10-28-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт явуулав. Судалгааны мэдээллийг PDA буюу гар компьютерт түшиглэн цуглуулав. Судалгааны мэдээллийн баазыг eSTEPS Questionnaire Designer–д суурилан eSTEPS –ийн орчинд үүсгэж, хэд хэдэн удаагийн туршилтаар хянан баталгаажуулав. PDA-д судалгааны мэдээллийн баазыг хуулбарлаж, шилжүүлэн

суулгаснаар мэдээлэл оруулах үеийн судлаачийн санамсаргүй болон логик алдаанаас сэргийлэх хязгаарлалтыг бүрдүүлэв.

Судалгааны хүн амыг түүвэрлэхдээ 4 үе шаттай, кластер түүврийн аргыг ашигласан ба түүврийн үе шат бүрийн нэгжийн сонголтыг PDA гар компьютерт зориулан зохиосон Sampling 1.0 программын тусламжтай хийв. Мэдээллийн боловсруулалтад SPSS18 программын комплекс түүврийн модулийг ашиглалаа. ХБӨ, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, хянах, эрт илрүүлэх аргуудын талаарх хүн амын мэдлэг, хандлагын одоогийн түвшинг давтамжаар тооцоолон гаргав.

Хэмжилтийн үр дүн (стандарт хазайлт) болон бүлгүүдийн хоорондын (нас, хүйс, байршил) ялгааг комплекс түүврийн Adjusted Pearson χ^2 статистикын аргаар 95 хувийн итгэх хязгаараар (95%CI) тооцоолон гаргав. Түүврийн нэгж бүрт харгалзах хүн амын болон түүврийн жинг тооцож өгөгдлийн баазад нэгтгэв. Хоёр судалгааны өгөгдлийн баазуудыг нэгтгэн, хувьсагчдыг дахин кодолж, суурь болон давтан судалгааны үр дүнгийн хоорондын ялгааг комплекс түүврийн Adjusted Pearson χ^2 статистикын аргаар 95 хувийн итгэх хязгаараар (95%CI) тооцоолон гаргав.

ХБӨ-ний талаарх ерөнхий мэдлэг, хандлагыг судалсан дүнгээр хүн амын 90.2 хувь нь халдварт бус өвчнүүд нь Монголчуудын дунд түгээмэл тохиолддог гэдэгтэй санал нийлж байгаа ч 10 хүн тутмын 6 (60.7%) нь халдварт бус өвчнүүд нь халдварт өвчинтэй харьцуулахад аюул багатай гэж үзсэн хэвээр байна. Харин өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад халдварт бус өвчнийг дутуу үнэлэх хандлага нийт хүн ам, ялангуяа эмэгтэйчүүд, 15-34 насны залуу хүн амын дунд буурч буй эерэг үр дүн ажиглагдлаа.

Судалгааны хүн амын 93.7 хувь нь монгол хүмүүс архи согтууруулах ундааг хэрэглэхдээ ихэвчлэн нэг дор их хэмжээгээр уудаг гэдэгтэй санал нийлж байна. Хөдөөгийн хүн амын дунд монгол хүмүүсийн архи, согтууруулах ундааг нэг дор ихээр хэрэглэдэг сөрөг зан үйлийг буруушаах эерэг хандлага нэмэгдэж буй дүн ажиглагдлаа. Хүн амын дийлэнх (95.3%) нь тэмдэглэлт өдрүүдээр архи согтууруулах ундааг их хэмжээгээр хэрэглэдэг ба найз нөхөд дарвиж архидах явдал хамгийн гол (89.5%) түгээмэл шалтгаан болж буй хэвээр байна. Архины хамааралтай болсныг илэрхийлэх шинж болох өглөө сэрэнгүүт архи уух нь 7.3 хувиар (хотод 7.1%, хөдөөд 8.49) буурсан боловч энэ дадал эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 4 дахин их, хөдөө орон нутагт хотоос их байна.

Тамхины хор хөнөөлийн талаарх хүн амын ойлголт ерөнхийдөө хангалттай байгаа нь тэдний 99.7 хувь нь энэ тухай сайн мэдэж байгаагаар илэрхийлэгдэж байна. Гэхдээ 5 хүн тутмын 1 нь (22.1%) тамхины эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийн талаар дутуу ойлголттой байна. Ялангуяа 15-24 насны өсвөр үеийн залуучуудын дунд тамхийг бага хэмжээгээр хааяа хэрэглэвэл эрүүл мэндэд хор нөлөө учруулахгүй гэсэн буруу ойлголт түгээмэл байна. Дам тамхидалтын хор нөлөөний талаарх хүн амын ойлголт хангалттай байгаа нь судалгааны хүн амын 99.5 хувь аюултай гэж хариулснаар илэрхийлэгдэж байна. Гэсэн хэдий ч хүн амын бараг тал хувь (49.3%), ялангуяа эрэгтэйчүүдийн дунд дам тамхидалтын хор нөлөөнөөс өөрсдийн эрүүл мэндээ хамгаалах эерэг хандлага дутмаг байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад дам тамхидалтаас урьдчилан сэргийлэх талаарх хандлага эерэгээр өөрчлөгдсөн нь ажиглагдлаа. Энэхүү эерэг өөрчлөлт эрэгтэйчүүд болон залуучуудын дунд илүү байв. Тухайлбал, 35-44 насны эрэгтэйчүүдийн бараг тал хувь нь (49.4%) хэн нэгэн тэдний гэрт тамхи татахыг хүлээн зөвшөөрдөггүй гэсэн нь өмнөх судалгааны дүнгээс 16.3 хувиар өссөн байна. Суурь судалгааны дүнтэй харьцуулахад энэхүү сэргийлэх хандлага эрэгтэйчүүдийн дунд 11 хувиар, 15-24 насныхны дунд 9.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Судалгаанд хамрагдсан хүн амын 65.0 хувь нь жимс, хүнсний ногоог өдөр бүр хэрэглэх нь “чухал”, 27.8 хувь нь “маш чухал” гэж үзсэн байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад жимс, хүнсний ногоог өдөр тутам хэрэглэх нь “чухал” гэсэн эерэг хандлага бүхий хувь нэмэгдсэн байна.

Жимс, хүнсний ногооны өдөр тутмын тогтмол хэрэглээний талаарх сэргийлэх хандлага хотын хүн амын дунд түгээмэл байсан ба ялангуяа залуучуудын дунд ихэссэн нь ажиглагдлаа.

Жимс, хүнсний ногооны хэрэглээ хязгаарлагдмал байгаад нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс нь өндөр үнэ (69.8%), импортын жимс, хүнсний ногооны чанар, аюулгүй байдалд итгэлгүй байдал (36.9%) байв. Түүнчлэн хөдөө орон нутгийн хүн амын 22,1 хувь нь жимс, хүнсний ногооны хангамж муугаас хангалттай хэрэглэж чаддаггүй байна.

Хүн амын дийлэнх (90.7%) нь Монголчууд хоол хүнсэндээ давс хэт их хэрэглэдэг гэж үзэж байна. Хүн амын 76.9 хувь нь хоол хүнсэндээ хэрэглэж буй давсныхаа хэмжээний талаар санаа тавьж байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 10.4 хувиар нэмэгджээ. Давсны эрсдэлийн талаарх хувь хүмүүсийн энэхүү эерэг хандлага эрэгтэйчүүд, залуучууд, хөдөөгийн хүн амын дунд илүү нэмэгдсэн байна. Далд давсны хэрэглээний талаарх мэдлэг нийт хүн ам, ялангуяа эрэгтэйчүүдийн дунд сайжирч буй байдал ажиглагдаж байгаа ч хүн амын 63.5 хувь нь кетчуп, 58.8 хувь нь цагаан талхны давсны агууламжийн талаар ойлголтгүй, 10 хүн тутмын 4 нь (43.7%) шарсан төмсөнд их хэмжээний давс агуулагддаг болохыг мэдэхгүй байна.

Судалгааны насны 5 хүн тутмын 1 нь (22.3%) дасгал, хөдөлгөөн хийх зохистой давтамжийн талаар мэддэггүй байна. Дасгал хөдөлгөөнийг тогтмол хийдэггүй шалтгааныг тодруулахад хүн амын 32,9 хувь нь цаг зав гардаггүй, 25.2 хувь дасгал хөдөлгөөн хийх сонирхолгүй, 18,3 хувь хэрхэн идэвхитэй хөдөлгөөнтэй байх талаар сайн мэддэггүй гэсэн байна. Суурь судалгааны дүнтэй харьцуулахад дасгал хөдөлгөөн тогтмол хийхийн ач холбогдлын талаарх ойлголт залуучууд, хөдөөгийн хүн амын дунд нэмэгдсэн байна. Идэвхтэй дасгал хөдөлгөөнийг хэрхэн хийх талаарх ойлголтын дутмаг байдал эрэгтэй (8.9%), эмэгтэй (10.7%) хүмүүсийн дунд тус тус буурсан байна.

Хүн амын дийлэнх хувь (70.1%) нь сүүлийн 6 сард биеийнхээ жинг хэмжсэн бөгөөд энэхүү дадал эмэгтэйчүүдийн дунд их хувийг эзлэж байна. Судалгаанд хамрагдсан хүн амын талаас илүү хувь (63.8%) нь биеийн жингээ хэвийн хэмжээнд байлгах нь “чухал” гэсэн бол 3 хүн тутмын нэг (29.6%) нь “маш чухал” гэж хариулсан байна. Биеийн жиндээ анхаарах, хяналт тавих хандлага хүн амын дунд, ялангуяа залуучууд, хотын хүмүүсийн дунд нэмэгдсэн байна.

Энэхүү судалгаагаар эрсдэлт хүчин зүйлсийн эрүүл мэндийн бодит нөлөөллийн талаарх хүн амын нийтлэг хандлагын өөрчлөлтийг тодорхойлсон. Архины хэрэглээний үр дагаварын талаарх мэдлэг бүх насны бүлгийнхний дунд хүйс, байршлаас хамаарахгүйгээр нэмэгдсэн байна.

Тамхи татах нь эрүүл мэндэд «бага зэрэг аюултай» гэсэн хандлагатай эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс 1.92 дахин их байгаа боловч тамхи татах нь эрүүл мэндэд «аюултай» гэсэн хандлага эмэгтэйчүүд болон 15-34 насны залуучуудын дунд нэмэгдсэн байна.

Жимс, ногоо хэрэглэх нь эрүүл мэндэд сайнаар нөлөөлдөг гэсэн эерэг хандлага хүн амын дунд нэмэгдэж байгаа боловч жимс ногоо бага хэрэглэснээс эрүүл мэндэд учрах ямар ч эрсдэл байхгүй гэж үзэх хандлага эрэгтэйчүүд болон хөдөөгийн хүн амын дунд давамгайлж байна. Суурь судалгааны дүнтэй харьцуулахад 15-34, 55-64 насны бүлгийн хүмүүс, эмэгтэйчүүдийн дунд жимс ногоо бага хэрэглэх нь эрүүл мэндэд аюултай гэсэн хандлага нэмэгдсэн байна.

Давс ихтэй хоол хүнс хэрэглэх нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэсэн хандлага нийт хүн амын дунд нэмэгдсэн байна.

Хөдөлгөөний хомсдол эрүүл мэндэд “аюултай” гэсэн эерэг хандлагатай хүмүүсийн эзлэх хувь насны бүлэг, байршил, хүйсийн ялгаагүйгээр нэмэгдсэн байна. Илүүдэл жинтэй байх нь эрүүл мэндэд аюултай гэсэн эерэг хандлага хүн амын дунд нэмэгдэж байгаа боловч илүүдэл жинтэй байх нь эрүүл мэндэд “бага зэргийн аюултай” гэсэн хандлага эрэгтэйчүүдийн дунд байсаар байна.

Судалгааны хүрээний хүн амын 44.4 хувь ЦДИ-ийн талаар огт мэдэхгүй эсвэл сонссон төдий ойлголттой, уг асуудлаарх эрэгтэйчүүдийн мэдлэгийн түвшин эмэгтэйчүүдээс харьцангуй доогуур байна. ЦДИ-ийн талаарх 15-34 насны залуучуудын мэдлэгийн түвшин ахимаг насныхантай харьцуулахад хангалтгүй байв. Хүн амын дийлэнх нь Монголчууд цусны даралтаа тогтмол үзүүлж, хянуулах шаардлагатай гэж үздэг боловч, тэдний 43.5 хувь “тийм ч чухал гэж боддоггүй”, 21 хувь “хэмжүүлэх шаардлагатай гэдгээ мэдээгүй”, 20.9 хувь цаг зав гардаггүйн улмаас цусны даралтаа тогтмол хэмжүүлж чаддаггүй байна.

Хүн амын дийлэнх нь цусны даралтыг бууруулахад амьдралын хэв маягаа өөрчлөхөөс илүүтэйгээр эмийн эмчилгээнд найдаж байна. Судалгааны хүрээний хүн амын 22.1 хувь биеийн жингээ бууруулах, 15 хувь хооллолтын хэв маягаа өөрчлөх, 10.5 хувь идэвхтэй хөдөлгөөнтэй байх нь цусны даралтыг бууруулахад нөлөөлөхгүй гэж үздэг байна. Цусны даралт ихсэлт, түүний хяналтын талаарх нийт хүн амын мэдлэг, хандлагад төдийлөн нааштай өөрчлөлт гараагүй байгаа ч, эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөнтэй байх нь цусны даралтыг бууруулахад нөлөөлнө гэсэн хандлага нэмэгдсэн байна.

15-64 насны хүн амын талаас илүү хувь (55.3%) нь ЗСӨ-ний талаар тодорхой ойлголттой байсан бөгөөд энэхүү ойлголт эмэгтэйчүүдийн дунд түгээмэл байна. Харин эрэгтэйчүүд болон 15-34 насны залуучуудын дунд мэдлэгийн түвшин хангалтгүй байна. ЗСӨ-ний эрсдэл, амьдралын хэв маягийн хоорондын хамаарлын

талаар “мэдэхгүй” гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь 15-24 насныхны дунд хамгийн өндөр байв. Ялангуяа илүүдэл жин (8.6 %), ахимаг нас (15.1 %)-ны тухай ойлголт залуучуудын дунд дутмаг байна. Цус харвалтын талаарх хүн амын мэдлэгийн түвшин нийт хүн амын дунд дутмаг байна.

Суурь болон давтан судалгааны дүнг харьцуулан үзэхэд ЗСӨ, түүний тархалт, өвчлөх эрсдлийн талаарх ойлголт, мэдлэг ерөнхийдөө сайжирсан байна. Цус харвалтын талаар эмэгтэйчүүд илүү ойлголттой байсан ба “бага зэрэг мэднэ” гэж хариулсан хөдөөгийн хүн амын эзлэх хувь нэмэгдсэн байна. Гэсэн хэдий ч цусны даралт ихсэлт нь харвалтын эрсдэлийг нэмэгдүүлдэг тухай ойлголтод өөрчлөлт гараагүй байна. Өөрийгөө ЗСӨ-өөр өвчилж болзошгүй талаарх хүн амын хандлага нас, хүйс болон байршлаар ялгаатай өөрчлөлт ажиглагдаагүй боловч ЗСӨ-өөс сэргийлэх боломжийн талаарх нийт хүн амын мэдлэгийн түвшин нэмэгдсэн байна. Хүн амын бараг тал хувь нь (47.8%), ялангуяа эрэгтэйчүүд чихрийн шижингийн талаар мэдлэг дутмаг байна. Судалгааны хүн амын (78.2%) ихэнх хувь нь чихрийн шижингээс сэргийлэх боломжтой гэж ойлгодог байна. Гэвч, хүн амын зөвхөн 25,7 хувь чихрийн шижингээс хэрхэн сэргийлэх талаар эрүүл мэндийн ажилтнаас зөвлөгөө авчээ.

Хөдөөгийн хүн ам, эрэгтэйчүүд, залуу насны хүн амын дунд чихрийн шижингийн талаарх ерөнхий ойлголт суурь судалгааны дүнтэй харьцуулахад сайжирсан байна. Хөдөөгийн хүн амын 80.6 хувь чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 23,4 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн ажилтнууд чихрийн шижингээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх нь хөдөө орон нутагт нэмэгдсэн байна.

30-64 насны эмэгтэйчүүдийн 48.2 хувь нь хөхний өмөнгийн талаар огт мэдэхгүй буюу сонссон төдий байгаа бол дөнгөж 12.6 хувь нь сайн мэддэг гэсэн байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөхний өмөнгийн талаарх мэдлэг хотынхоос илүү байна. Эмэгтэйчүүдийн 87.9 хувь хөхөө өөрөө тэмтрэн хөхний өмөнгийн эрт үеийн шинж тэмдгийг илрүүлж болно гэж үздэг ба хөхөө өөрөө шалгаж хөхний эмгэг өөрчлөлтийг илрүүлж мэднэ гэж 67.7 хувь хариулснаас үзэхэд хөхний өмөнг эрт илрүүлэх боломж, өөрийн хяналтын талаарх хандлага хангалттай сайн байгааг харуулж байна. Судалгааны насны эмэгтэйчүүдийн 46.1 хувь гэр бүлийнхээ хэн нэг нь хөхний өмөнгөөр өвдчих бий гэж санаа зовдоггүй буюу эрсдэлт байдалд

орж болох талаар огт боддоггүй ба энэ хандлага хотын эмэгтэйчүүдийн дунд илүү байна.

Өнгөрсөн жилүүдэд эмэгтэйчүүдийн хөхний өмөнгийн талаархи ерөнхий ойлголт дорвитой нэмэгдээгүй ч, түүнийг эрт илрүүлэх боломжийн талаарх мэдлэг 13.6 хувиар, өөрийнхөө хөхийг шалгах тухай мэдлэг 7.1 хувиар нэмэгдсэн байна. Суурь судалгааны дүнтэй харьцуулахад эрүүл мэндийн ажилтнаар хөхөө шалгуулсан эмэгтэйчүүд 15,6 хувиар нэмэгдсэн ба ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдийн талаас илүү хувь (53,9%) эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан байна.

Монгол улсын 30-64 насны эмэгтэйчүүдийн 42.6 хувь нь умайн хүзүүний өмөнгийн талаар огт мэддэггүй буюу сонсох төдий ойлголттой байна. Судалгааны насны 10 эмэгтэй тутмын 6 нь (65.8%) эсийн шинжилгээ хийлгэх давтамжийн талаар тодорхой ойлголтгүй байна. Эсийн шинжилгээ хийлгэхгүй байгаагийн гол шалтгаан нь залуу насны эмэгтэйчүүдын хувьд “зав гардаггүй” (54.6%), ахимаг насны эмэгтэйчүүд хувьд (47.8%) “шаардлагатай гэж мэдээгүй” байгаа нь энэ талаарх мэдлэг дутмаг, хамруулалт хангалтгүй байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдсан 2 эмэгтэй тутмын 1 нь вакцин хийлгэснээр умайн хүзүүний өмөнгөөс сэргийлэх боломжтой талаар ойлголтгүй байв. Гэвч суурь судалгааны дүнтэй харьцуулахад судалгаанд оролцогчдын умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэх шинжилгээг хийлгэх давтамжийн талаарх мэдлэг 28 орчим хувиар, умайн хүзүүний өмөнгөөс урьдчилан сэргийлэх вакцинаар сэргийлэх боломжтой талаарх мэдлэгийн түвшин 30 хувиар тус тус нэмэгдсэн байна. Сүүлийн 3 жилд умайн хүзүүний эсийн шинжилгээнд эмэгтэйчүүдийн 45.7 хувь хамрагдсан бөгөөд энэхүү үзүүлэлт хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд 54.2 хувь хүртэл нэмэгдсэн нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 17.2 хувиар ихэссэн байна.

Хүн амын дөрөвний гурав нь замын хөдөлгөөнд оролцохдоо өөрсдийн аюулгүй байдалдаа санаа зовж байна гэсэн нь Монгол улсад замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ) ихээхэн ноцтой асуудал болсныг харуулж байна. Хотын иргэдийн 80.8 хувь нь замын хөдөлгөөнд оролцохдоо аюул мэдэрч, аюулгүй байдалдаа санаа зовж байгаа бөгөөд хөдөөд энэ үзүүлэлт 17,1 хувиар бага байлаа. Судалгааны хүн амын 20 хувь нь суудлын бүсний ач холбогдлын талаарх мэддэг хомс, 30 хувь нь хэрэглэхийг хүсэхгүй байгаа нь суудлын бүсний хэрэглээний ач холбогдлыг ойлгуулах, хэрэглүүлж хэвшүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгааны дүнгээр Монгол улсын 15-64 насны хүн амын ХБӨ-ний зан үйлийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн талаарх ойлголт, хандлага нэлээд төлөвшиж, эрэгтэйчүүд, залуу насны болон хөдөөгийн хүн амын энэ талаарх ойлголт, хандлага нийтлэг байдлаар сайжирсан байна.

Нийт хүн амын дунд чихрийн шижин, хөх, умайн хүзүүний хавдар, тэдгээрээс сэргийлэх арга зам, өөрийн хяналтын талаарх ойлголт, хандлага сайжирч, итгэл үнэмшилтэй болсон ба эдгээр нь залуу насныхан болон хөдөө орон нутгийн хүн амын дунд илүүтэй ажиглагдаж байв.

Суурь болон давтан судалгааны дүнг харьцуулан үзэхэд сүүлийн 2 жилд зүрх судасны өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага зарим талаар нэмэгдсэн боловч энэхүү ихсэлт нь насны бүлэг, байрлалд (хөдөө, хот) ялгаатай, тогтмол бус байгаа нь цаашид энэ чиглэлээр тодорхой, бай бүлэгт чиглэсэн, тогтвортой мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг дорвитой авч хэрэгжүүлэх, боловсрол, харилцааны үйл ажиллагааг явуулах шаардлагатайг харуулж байна.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл, ММСС-ийн Эрүүл Мэнд төслөөс явуулсан хүн амын зан үйлийг өөрчлөх, амьдралын эрүүл хэв маягыг төлөвшүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд явуулсан үйл ажиллагаа нь “ХБӨ-ний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал” -ын суурь судалгаанаас тодорхойлон гаргасан эрсдэлт бүлгийн хүн амд илүү чиглэсэн, өвөрмөц арга хэмжээ болсныг уг судалгаанаас гарч буй үр дүнгүүд илэрхийлж байна. Одоогийн судалгааны дүн нь баримтад суурилсан аргад үндэслэн цаашид төслийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах, илүү чиглэсэн арга хэмжээг тодорхой бүлгүүдийн дунд авч хэрэгжүүлэхийг харуулж байна.

Судалгааны дүнгээс харахад цаашид халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэгийг улам бэхжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийн талаарх эрүүл, урьдчилан сэргийлэх, эерэг хандлагыг урамшуулах, нийт хүн амын дунд бий болсон Үүний тулд энэхүү эерэг хандлагыг тогтворжуулах нь чухал бөгөөд халдварын бус өвчинтэй холбоотой дадал, зан үйлийн өөрчлөлтийг урамшуулах зорилгоор үе шаттай үйл ажиллагааг цаашид улам дэмжих, судалгааны үр дүнд суурилан эрсдэлт хүчин зүйлсүүдийг үндэсний түвшинд бууруулах арга хэмжээний стратеги боловсруулах, засах механизмыг тогтоох, Монголын Мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төслийн тусламжтайгаар амжилттай хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тогтворжуулах шаардлагатай байна.

СУУРЬ БОЛОН ДАВТАН СУДАЛГААНЫ ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

	Суурь судалгаан ы дүн, хувиар (2010)	Давтан судалгааны дүн, хувиар (2013)
Халдварт бус өвчний талаарх мэдлэг ('Бага зэрэг мэднэ', 'Сайн мэднэ')		
Чихрийн шижингийн талаарх мэдлэг	34.8	52.3
Цусны даралт ихсэлтийн талаарх мэдлэг	53.4	55.5
Хөхний хорт хавдрын талаарх мэдлэг	38.9	51.8
Умайн хүзүүний хорт хавдрын талаарх мэдлэг	42.2	57.4
Зүрх судасны өвчний талаарх мэдлэг	46.6	55.3
Тархины харвалтын талаарх мэдлэг	44.2	50.5
Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг ('аюултай', 'маш аюултай')		
Илүүдэл жин	83.9	90.4
Хөдөлгөөний хомсдол	80.4	87.4
Жимс ногооны бага хэрэглээ	32.2	35.2
Давсны хэрэглээ	80.5	87.9
Тамхины хэрэглээ	96.6	96.2
Архины хэрэглээ	98.7	99.0
Хөхний хорт хавдрын талаарх мэдлэг, эрсдэлийн тухай ойлголт		
Би болон миний гэр бүлийнхэн хөхний хавдраар өвдөх магадлалтай	49.1	53.9
Өөрөө хөхөө шалган хөхний хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх тухай мэдлэг	80.5	87.9
Хөхний хорт хавдрыг өөрөө хэрхан шалгах тухай мэдлэг	63.3	67.7
Умайн хүзүүний хорт хавдрын талаарх мэдлэг, эрсдэлийн тухай ойлголт		
Би болон миний гэр бүлийнхэн умайн хүзүүний хорт хавдраар өвдөх магадлалтай	54.2	62.0
Вакцин нь умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлнэ. (M&E индикатор)	15.3	43.5

3 жил тутамд эсийн шинжилгээ сорил хийлгүүлэх тухай мэдлэг	6.0	34.2
Шаардлагатай гэж бодоогүй учир эсийн шинжилгээний сорил хийлгээгүй	63.1	37.4
Чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээний талаарх мэдлэг		
Чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх боломжой (M&E индикатор)	66.2	78.2
Эрүүл хооллолт	64.2	83.2
Эм хэрэглэх	9.1	55.0
Дасгал хөдөлгөөн хийх	27.9	51.0
Жингээ хасах	21.3	34.3
Тамхинаас гарах	15.5	26.7
Мэдэхгүй	26.4	10.2
Зүрх судасны өвчний эрсдэлт хүчин зүйлс		
Стресс	92.8	94.6
Илүүдэл жин	85.0	90.1
Тамхи татах	93.7	94.1
ЗСӨ-өөс урьдчилан сэргийлэх		
ЗСӨ-өөс урьдчилан сэргийлж болно (M&E индикатор)	89.5	93.0
Чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн ажилтнаас зөвөлгөө авсан	14.8	23.6
Цусны даралт ихсэхээс урьдчилан сэргийлэх аргууд		
Эм хэрэглэх	77.4	85.1
Жингээ хасах	65.1	67.6
Хооллолтын хэв маягаа өөрчлөх	71.1	75.9
Дасгал хийх	69.1	72.5